

**АЛБАН БЛАНК, АНХАН ШАТНЫ МАЯГТ БОЛОН ПРИНТЕРИЙН ХОР, ЦЭНЭГЛЭГЧ, БИЧИГ ХЭРГИЙН БУСАД БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2019 оны *02* сарын *26* өдөр

Нэг талаас: *Күүхэдүйн чигэрлэл* -ыг төлөөлж  
*Эрхлэлч* ажилтай *А. Амгиршоргал*

Нөгөө талаас: "Мөнгөн үсэг" ХХК-ны гүйцэтгэх захирал Г.Зоригт нар харилцан тохиролцож энэхүү гэрээг  
*239 Н.Б.Т.* үнийн саналаар байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Монгол улсын иргэний хууль болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталснаар хүчин төгөлдөр болно.

**Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

- 2.1 Захиалагч нь гүйцэтгэгчид захиалах албан бланк, маягтын баталгаажсан эхийг өгөх
- 2.2 Захиалах албан бланк, маягтын хэмжээ, тоо ширхэгийг үнэн зөв өгөх
- 2.3 Захиалах албан бланк, маягтын эх өөрчлөгдөх бол хэвлэлтэнд орохоос өмнө гүйцэтгэгчид мэдэгдэх
- 2.4 Хэвлэлтэнд орсноос хойш эхэд өөрчлөлт орох бол гарсан зардлыг хариуцах
- 2.5 Захиалах бүтээгдэхүүнийг 1-7 хоногийн өмнө захиалах
- 2.6 Бүтээгдэхүүний төлбөрийг тухайн сардаа төлж барагдуулах
- 2.7 Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хугацаандаа чанартай, өгсөн эх загвараар бүрэн хэмжээгээр бүтээгдэхүүнээ нийлүүлэхийг шаардах
- 2.8 Өгсөн эх загвараар хэвлэн нийлүүлээгүй нөхцөлд гэрэх хохирол, хариуцлагыг хүлээхгүй

**Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

- 3.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн өгсөн баталгаажсан эхээр захиалгыг стандартын дагуу хэвлэн нийлүүлнэ
- 3.2 Захиалсан анхан шатны маягт болон бусад бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нь чанартай хэвлэн эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгөх.
- 3.3 Захиалагчид хүлээлгэн өгөхдөө хүлээлгэн өгсөн зарлагын баримт, нэхэмжлэлийг 2 хувь үйлдэх
- 3.4 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс захиалагчид учирсан хохирлыг барагдуулах
- 3.5 Хэвлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ, эх загварыг заавраас өөрөөр өөрчилж болохгүй.
- 3.6 Захиалсан бүтээгдэхүүний эхийг бэлтгэхэд шаардлагатай мэдээллээр хангах, эхийг баталгаажуулахыг захиалагчаас хүсэх.
- 3.7 Чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үнийг тогтвортой байлгана.
- 3.8 Захиалагч төлбөрөө хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлбөрийг нэхэмжлэх, алданги тооцох

**Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага**

- 4.1 Гэрээнд тусгасан үүргээ биелүүлж, гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруутай тал нь нөгөө талдаа тухайн асуудлыг барагдуулж шийдвэрлэнэ.
- 4.2 Чанаргүй дутуу бараа үйлчилгээг нийлүүлэх, хүлээн авахыг хориглоно.

**Тав. Маргаан шийдвэрлэх**

- 5.1 Талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд харилцан зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулснаар тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 5.2 Энэхүү гэрээгээр үүссэн маргааныг талууд харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Эс чадвал маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Зургаа. Гэрээний үйлчлэх хугацаа**

6.1 Гэрээний үйлчлэх хугацаа: 2019 оны *02* сарын *26* нээс 2020 оны *01* сарын *01* өдөр хүртэл байна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*А. Амгиршоргал*  
Утас: *99263506*

"Мөнгөн үсэг" ХХК-ны гүйцэтгэх захирал  
*Г. Зоригт*  
Утас: 99389928, 89203399, 98639928

